

## Нийгмийн хариуцлагын чиглэлээр 2013 онд хийсэн ажлын тайлан

1. “Багт шуудан хүргэх” үйлчилгээ нь цэвэр нийгэмд чиглэсэн үйлчилгээ юм. Учир нь чөлөөт хэвлэл мэдээллийг хөдөөгийн алслагдсан, тархай бутархай байршсан сум баг дахь нүүдэллэн амьдардаг хөдөөгийн малчид хөдөлмөрчдөд хүргэж, тэднийг цаг үеийн мэдээллээс хоцроолгүй, соёлын үрийг түгээж байдагтай холбоотой юм. Уг үйлчилгээг үзүүлэхэд маш их хөрөнгө хүч, цаг хугацаа шаардагддаг ба компани уг үйлчилгээнээс ихээхэн хэмжээний алдагдал үүрч ажиллаж байна. Одоогийн байдлаар Улсын хэмжээний нийт 340 гаруй сум тэдгээрийн 1558 багийн 1208-д буюу 77.8 хувьд нь жилдээ нийт 702 тонн сонин хэвлэлийг хүргэж байгаа бөгөөд саад бартаа бүхий 326 багуудад хүргэлтийг гэрээгээр болон дайвраар гүйцэтгэж байна. Үүний үр дүнд алслагдсан сум багийн малчид хөдөлмөрчид цаг үеийн мэдээллээс хоцрохгүй байж, үнэн бодит мэдээллийг богино хугацаанд олж авах нөхцөл бүрдэж байна. Ингэж бүх нийтийн үйлчилгээний үүргийг гүйцэтгэсэнээр жилдээ 1,2 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн.
2. Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран иргэдийг ухаалаг, цахим үнэмлэхжүүлэх ажилтай холбоотой тоног төхөөрөмж, нууц материалуудыг хөдөө орон нутаг, аймаг сумд шуудангийн үндсэн тарифаасаа 40%-ийн хөнгөлөлттэй тарифаар хүргэж, бэлтгэл ажлыг хангахад хамтран ажиллаа.
3. Монгол улсын ирээдүй болсон хүүхэд залуучуудыг гоо сайхан, соёлын өв тэгш, зөв хүмүүжилтэй болгон хүмүүжүүлэн төлөвшүүлэх зорилгоор Их, дээд, дунд сургуулиудтай хамтран сургуулиуд дээр марк сонирхогчдын дугуйлан, клуб байгуулан маркийг сурталчлан таниулах, марк цуглуулах сонирхол хүмүүжилтэй болгох 2,5 сая төгрөгийн төсөвтэй “Марк миний хобби” сэдэвт аянг уламжлал болгон зохион байгуулж ажилласан.
4. Хас банк, Ситинет зэрэг байгууллагуудтай хамтран хүүхэд багачууд, залуучуудыг шуудангаар үйлчлүүлэх, зөв соёлтой харилцааг бий болгох үүднээс зургийн болон ил захидал, зохион бичлэгийн уралдааныг 2 удаа зарлан явуулж, түрүүлсэн бүтээлүүдийг телевиз болон сонингоор сурталчилан олон нийтэд танилцуулах, зохиогч хүүхэд багачуудыг урамшуулах, тэдний авъяас чадварыг нээн гаргах ажилд 30 сая төгрөгийн зардал гаргасан байна.
5. Холбоо Мэдээллийн Дээд сургуулийн шуудангийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх зорилготой “Шуудангийн анги”-ийн оюутнуудыг цагийн цалинтай ажилд ажиллуулах, дадлагажуулах ажлыг байнга зохион байгуулдаг ба тэдэнд байгууллагын удирдах аппаратын ажилчдаас шуудангийн мэргэжлийн чиглэлийн хичээлийг заахаас гадна үйлдвэрлэлийн болон технологийн дадлагыг газар дээр нь хийлгэж, бэлтгэдэг. 2011 онд төгссөн шуудангийн мэргэжлийн оюутнуудыг ажлын байраар хангасан.
6. Хамтын гэрээний үүргээ биелүүлж 15 сая төгрөгийн буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлсэнээс гадна 22 ажилтаны орон сууцны урьдчилгаа төлбөрт зориулж 60 сая төгрөгийн тэтгэмж олгосон. Мөн ахмад настнуудад нэмэгдэл тэтгэмж, амралт сувиллын зардалд 20 гаруй сая төгрөгийг зарцуулсан байна.
7. Ажилчдын эрүүл ажиллаж амьдрах, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөхөд зориулж 15 сая төгрөгийн төсвөөр фитнес, чийрэгжүүлэлтийн танхимыг

тохижуулж, тоног төхөөрөмжөөр хангасанаас гадна Эмч-зааварлагчийн орон тоог шинээр бий болголоо.

“Архигүй Монгол хүн” хөтөлбөр, “Тамхи, мансууруулах бодистой тэмцэх” ТББ, Мянганы сорилтын сантай хамтран 1 сая төгрөгийн төсөвтэй “Архи, тамхигүй эрүүл ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажилчдыг 2 удаагийн сургалтанд хамруулж, гарын авлага, танилцуулга материалаар хангаж ажиллаа.